



## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**БАТЛАВ.**  
**САЛБАРЫН УЛСЫН**  
**ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ**

/Албан тушаал/



**Б.НАРАНГАРАВ**

/Гарын үсгийн тайлал/

### ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

2024 оны 02 дугаар сарын 07

Дугаар 13-07/08

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан  
өвчний даатгалын санд урьдчилан  
сэргийлэх хяналт шалгалт  
хийх тухай

#### Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>3</sup> дугаар зүйлийн 5<sup>3.1</sup>, 5<sup>3.2</sup>, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-нд тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын байгууллагын Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд Төрийн хяналт шалгалтын тухай, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам” болон бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмж боловсруулж, дүгнэлт өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хяналт шалгалтын зорилго оршинс

#### Хоёр. Шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектын нэр

2.1. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал;

2.2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”-ын 1.4-т заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2021-2023 оны төлөвлөгөөнд хөндлөнгийн караат үз аудитын байгууллагаар гаргуулсан дүгнэлт;

1511100023

2.3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”-ын 3.2-т заасны дагуу 2021-2023 оны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, түүний үр дүнгийн талаарх тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд танилцуулсан байдал;

2.4. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”-ын 1.5-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс 2021-2023 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан байдал;

2.5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн цахимжилт;

2.6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжилт авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд;

2.7. Өмнөх онуудад Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн акт, албан шаардлагын биелэлт, үр дүн.

#### **Гурав. Хяналт шалгалтын төрөл**

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

#### **Дөрөв. Шалгалтын арга**

4.1. Улсын (ахлах) байцаагч нь Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны төлөвлөлт, гүйцэтгэлийг санхүүгийн анхан шатны баримт материалтай тулган шалгах;

4.2. 2021-2023 онуудын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлөвлөлт, үндэслэл, хэрэгжүүлэх арга хэмжээ, гүйцэтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хэрхэн сонгодог, сургалт, бусад арга хэмжээний чанар, үр дүнг хэрхэн тооцдог, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн тоо буурсан эсэхийг холбогдох баримт материалд тулгуурлан шалгаж, дүгнэлт өгөх;

4.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 2021-2023 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, түүний үр дүнг санхүүгийн үндсэн баримттай тулган шалгах;

4.4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авч буй нийт тэтгэвэр авагчдын тэтгэвэр тогтоолтын үндэслэлийг хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт материалд тулгуурлан шалгах;

4.5. Даатгуулагчдад 2021-2023 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж болон хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрийн бодолт, олголтыг үндсэн баримттай тулган шалгах;

4.6. 2021-2023 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчдад олгосон сувиллын тусламж, үйлчилгээний хувьсах зардлыг үндсэн баримттай тулган шалгах;

4.7. 2021-2023 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгах;

4.8. Шаардлагатай тохиолдолд ажил хөдөлмөр эрхэлж байгаа зарим тэтгэвэр авагчдын ажлын байран дээр очиж холбогдох бичиг баримтуудтай танилцах, санал, дүгнэлт гаргах;

4.9. Шалгаж байгаа тэтгэврийн хувийн хэрэг дэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын актыг эргэлзээтэй гэж үзвэл түүнийг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл, бусад хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, холбогдох арга хэмжээ авах;

4.10. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын төрлийг хүснэгт №-01, сангийн зарцуулалтын төрлийг хүснэгт №-02, нэгтгэлийг хүснэгт №-03-аар тус тус нэгтгэн гаргаж, сангийн орлого, зарлагад дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгөх;

4.11. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчдаас тогтоосон акт тус бүрээр хүснэгт №-04, зөрчлийн нэгтгэлийг хүснэгт №-05-аар тус тус гаргаж ирүүлэх;

4.12. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуугийн тэтгэвэр авч буй иргэдийн судалгааг хүснэгт № 6-аар гаргаж, дүгнэлт өгөх;

4.13. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуугийн тэтгэвэр авч буй иргэдийн ажил хөдөлмөр эрхлэлтийн судалгааг хүснэгт № 7-оор гаргаж, дүгнэлт өгөх;

4.14. Шаардлагатай тохиолдолд төрийн бусад байгууллагад хүсэлт гаргаж холбогдох мэдээллийг гаргуулан авах;

4.15. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймаг, нийслэлийн Нийгмийн даатгалын газрын удирдлагаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээг авч ажиллах.

#### **Тав. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч**

Шалгалтыг яам, харьяа агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг дэх салбарын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх Нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагч нар хийж гүйцэтгэнэ.

Нийгмийн даатгалын ерөнхий газарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч П.Батжаргал ахалж, Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч П.Хорлоо, Ч.Амарсанаа нар хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

Шаардлагатай тохиолдолд Хөдөлмөр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын (ахлах) байцаагч болон бусад холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулж болно.

#### **Зургаа. Хяналт шалгалт эхлэх болон дуусах хугацаа**

Хяналт шалгалтыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэнэ.

#### **Долоо. Шалгалтын дүнг танилцуулах**

7.1. Шалгалтын дүнг шалгалтад хамрагдсан байгууллагын удирдлагад танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын (ахлах) байцаагчийн акт, дүгнэлт, албан шаардлага өгч биелэлтэд хяналт тавьж ажиллана.

7.2. Улсын /ахлах/ байцаагчид шалгалтын дүнг нэгтгэн хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг байлцуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас гарсан шийдвэр, шалгалтын танилцуулгыг Засгийн газрын 479 дүгээр тогтоолоор баталсан "Хяналт шалгалтын нийтлэг журам"-ын 5 дугаар бүлгийн 25 дахь хэсэгт заасны дагуу

боловсруулж, хавсралт хүснэгт №1-7-гийн хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт цаасан /цахим g\_ganbaatar2002@uapoo.com хаягаар/ хэлбэрээр 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлсэн байна.

7.3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газраас ирүүлсэн шалгалтын дүн, нэгтгэн холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлын шийдвэрийг нэгдсэн танилцуулга, хавсралт хүснэгтийн хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газарт 2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ.

7.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газар нь агентлагаас ирүүлсэн хяналт шалгалтын дүнд дүн шинжилгээ хийж, нэгдсэн үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулан удирдлагад танилцуулж, шийдвэрийг холбогдох агентлаг, газруудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.

7.5. Хяналт шалгалтын дүн мэдээг Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, улсын байцаагч, хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч шалгалтын хувийн хэргийг бүрдүүлэн байгууллагын архивд хүлээлгэн өгнө.

-----oOo-----

## ..... аймаг, дүүргийн НДГ-ын ҮОМШӨ-ний даатгалын сангийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт

/ мян төг /

д/д	Орлогын төрөл	2021 он			2022 он			2023 он					
		А/О / Д/Ч тоо	Төл	Гүйц	Хувь	А/О / Д/Ч тоо	Төл	Гүйц	Хувь	А/О / Д/Ч тоо	Төл	Гүйц	Хувь
1	Ажил олгогчийн төлсөн ҮОМШӨ-ний даатгал												
2	Даатгуулагчийн төлсөн ҮОМШӨ-ний даатгал												
3	Улсын төсвийн санхүүжилт												
4	Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү												
5	Актаар төлөгдсөн шимтгэл												
5	Хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги												
6	Аалагаас барагдуулсан:												
7	НДШ-ийн өрөнд хураагдсан барааны орлогоос орсон												
8													
9	Бусад эх үүсвэр												
10	ДҮН												

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ...../

..... аймаг, дүүргийн НДГ-ын ҮОМШӨ-ний даатгалын сангийн 2021-2023 оны зарцуулалт

2024 оны .....-р сарын .....-ны өдөр.

Д/д	Зардлын төрөл	2021 он		2022 он		2023 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
А	Б	1	2	4	5	6	
1	Тахир дутуугийн тэтгэвэр						
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр						
3	ХЧТА-ны тэтгэмжид						
4	ХЧ-ыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрт						
5	Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд						
6	Хувьсах зардалд						
7	урьдчилан сэргийлэх зардалд						
8	Банкны үйлчилгээний хөлсөнд						
9	Төвлөрүүлсэн						
10							
11							
12							
13	Г.М						
14	ДҮН						

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ...../

/ мян төг /

.....аймаг, дүүргийн НДГ-ын ҮОМШӨ-ний даатгалын сангийн 2021, 2022, 2023 оны орлого, зарлагын нэгдсэн товчоо

/ Мянган төгрөг /

д/д	Огноо	2024 оны .....-р сарын .....-ны өдөр.										Эцсийн үлдэгдэл 2023.12.31										
		Эхний үлдэгдэл 2021.01.01	Ажил олгогчийн төлсөн шимтгэл	Даятгуулагчийн төлсөн шимтгэл	Улсын төсвөөс олгосон санхүүжилт	Сангийн чөлөөт үлдэгдлийг банкнд хадгалуулсны хүү	Актаар төлөгдсөн шимтгэл	хугацаа хэтрүүлсэн алданы оногдуулсан алданы	Алагаас баярласан	Бусад эх үүсвэр	Орлогын дүн	Тахир дутуугийн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	ХЧ-ыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрт даятгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд	Хувьсах зардалд	Урьдчилан сөрөлтөх зардалд	Банкны үйлчилгээний хөлсөнд	Төлөрүүлсэн	Зарлагын дүн	Эцсийн үлдэгдэл 2023.12.31		
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
1	2021																					
2	2022																					
3	2023																					

НЭГТГЭСЭН: НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ.....!

.....АЙМАГ, ДҮҮРГҮЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

**ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ТӨЛБӨР ЗӨРЧИЛИЙН ЖАГСАНТ**

2024 оны .....р сарын .....ны өдөр. Летрагөөр/

д/д	Улсын/өдөлх/ байцаагчийн агын		Тэтгээр авагчийн			Зөрчлийн шалтгаан	Сарын тэтгээр			Тэтгээр авсан сарын тоо	Төлбөр		Үүнээс: Шийдвэрлэсэн	ХЦГА-ны тэтгэх болон хөдөлгөөнийг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөртэй холбоотой	Даатгуулагчид олгосон бүтцийн туслах, үйлчилгээний хувьсах зардалтай холбоотой		Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгөтэй холбоотой	
	Ок, сар, өдөр	Дугаар	Тэтгэрийн төрөл	Хувиийн хэргийн дугаар	Оюог нэр		Шалгахас өмнө авч байсан	Шалгаснаар олгох	Зөргүй/х...		Илүү	Дулуу			Нөхөн олгох	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо

НИЙГЭМДИЙН ХАМГААЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГУУ



.....АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуугийн тэтгээр авч буй иргэдийн судалгаа

2024 оны .....р сарын .....ны өдөр.

№	Овог	Нэр	Регистр	Хүйс	Төрсөн огноо	Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан		Тогтоогдсон		Сунгалдсан		Өргөдөл өгсөн огноо	Тэтгээр авсан хугацаа /жишээр/	Ажил эрхэлж байсан байгууллага, Албан тушаал	Тайлбар
						ҮО	МШГ	Онош	Хувь	Онош	Хувь				
1															
2															
3															
4															
5															
6															
7															
8															
9															
10															
11															
12															
13															
14															
15															

НЭГТГЭСЭН: НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ...../...../

.....АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуугийн тэтгэвэр авч буй иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

2024 оны .....р сарын .....ны өдөр.

№	Оног	Нэр	Регистр	Хүйс	Төрсөн огноо	Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан		Тогтоогдсон		Сунгилдсан		Бүрхдөл өгсөн огноо	Тэтгэвэр авсан хугацаа /жигээр/	Ажил эрхэлж байсан байгууллага, Албан тушаал	Огноо ажил эрхэлж байгаа байгууллага, Албан тушаал	Тайлбар
						ҮО	МШӨ	Онош	Хувь	Онош	Хувь					
1																
2																
3																
4																
5																
6																
7																
8																
9																
10																
11																
12																
14																
15																

НЭГТГЭСЭН: НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ...../